



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/179

Сүхбаатар сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих" журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:


- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Татварын хэлтсийн Татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга
- Аймгийн Цагдаагийн газрын Нийгмийн хэв журам хамгаалах тасгийн дарга
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч
- Сэлэнгэ аймаг дахь Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн /тохиролцооноор/

2.Согтууруулах ундаа худагдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/127 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.ОРГИЛ